

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦСЭН
ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2019 оны 05 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа тус Байнгын хорооны даргыг томилох асуудлыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасныг тус тус баримтлан хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.


Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Төмөрбаатарын Аюурсайханыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар сонгохоор нэр дэвшүүлснийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



О.СОДБИЛЭГ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

**Байнгын хорооны даргыг
сонгох, чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Төмөрбаатарын Аюурсайханыг сонгосугай.

2. Улсын Их Хурлын гишүүн Отгонбилэгийн Содбилэгийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг